



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН

**«Монгол-Хятадын эдийн засаг, худалдааны хамтын
ажиллагааны өнөөгийн байдал, хэтийн төлөв» олон
улсын эрдэм шинжилгээний бага хурал**

БНХАУ-ЫН ГАДААД ХУДАЛДААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХУВЬСАЛ, ӨӨРЧЛӨЛТ

М.Эрдэнэбаяр Ph.D, ЭША

2022.06.21

- БНХАУ-ын “шинэтгэл, нээлттэй бодлого” эхэлснээр, гадаад худалдааг чөлөөлөх, аж үйлдвэрийг хөгжүүлж экспортод чиглэх, олон улсын интеграцид нэгдэх стратеги хэрэгжүүлж, дэлхийн худалдааны томоохон тоглогч болсон бол, сүүлийн үеийн стратеги нь тогтвортой байдлыг хангах, олон улсад нээлттэй байдлаа гүнзгийрүүлэх, экспортоос гадна импортыг чухалчилах, олон улсын худалдаа, эдийн засгийн дэг журамд манлайлал үзүүлэх зэрэг болж өөрчлөгдөж буй.
- Монгол Улсын хувьд, гадаад худалдааны болон түүний хөгжлийн оновчтой бодлогоор дотоодын үйлдвэрлэлийн тогтвортой тогтолцоог бий болгох, улмаар бүс нутгийн аж үйлдвэрийн хэлхээнд тодорхой байр суурь эзлэх шаардлага тулгамдаж байна.
- Энэ илтгэлд БНХАУ-ын 1979 оноос явуулж ирсэн гадаад худалдааг хөгжүүлэх бодлого, цаашдын чиг хандлагад товч шинжилгээ хийж, анхаарах асуудлын талаар санал бодлоо хуваалцлаа.

- Ковид-19 цар тахлын нөлөөгөөр дэлхийн үйлдвэрлэлийн гинжин хэлхээнд тасалдал үүссэн нь нийт аж үйлдвэрийн тогтолцоонд нөлөөлж, олон улсын хөдөлмөрийн хуваарьт томоохон өөрчлөлт явагдах нь тодорхой боллоо. Цаашид нийлүүлэлтийн сүлжээ аажмаар бүс нутгийн шинжтэй болж, богино гинжин хэлхээ зонхилох магадлалтай байна.
- Сүүлийн хоёр жил дэлхийн томоохон эдийн засгуудийн өсөлт эрс саарсан ч БНХАУ-ын эдийн засаг 2020 онд 2.3 хувь, 2021 онд 7.9 хувь тус тус өссөн нь харьцангуй сайн үзүүлэлт болсон.
- 2021 оноос тус улсын XIV таван жилийн төлөвлөгөө (2021-2025) хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2035 он гэхэд модернизацийг, 2050 оны орчим орчин үеийн чинээлэг, хүчирхэг улсыг бүрэн бий болгохыг зорьж байна.
- Хөгжлийн дараагийн үе шатанд орох: Хөрөнгө оруулалт, экспортод тулгуурласан ЭЗ-ийн өсөлтийн үеийг дуусгаж, үйлчилгээ, дотоод хэрэглээ, бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн “шинэ хэв маяг”-руу шилжиж байна.

Хөгжлийн үе шат (Ростов, Модернизацийн онол)

1. Уламжлалт нийгэм
2. Шилжилтийн нийгэм буюу хөөрөхийн өмнөх үе
3. Хөөрөх үе
 - Хотжилт, аж үйлдвэржилт
 - Технологийн хувьсгал
4. Насанд хүрэх
 - ЭЗ-т төрөлжилт, шинэ төрлийн үйлдвэрүүд
 - Үйлдвэржилт, ХО-аас дотоодын хэрэглээнд шилжих
 - Дэд бүтцийн хурдтай хөгжил
5. Масс хэрэглээний үе
 - Аж үйлдвэрийн суурь ЭЗ-т ноёрхоно, анхдагч секторын ЭЗ дахь нөлөө багасна
 - Өндөр үнэ цэнэтэй хэрэглээний бүтээгдэхүүнүүд нийтийн хэрэглээ болно
 - Хотжилт амьдралын хэв маяг болно

Эдийн засгийн хөгжлийн үе шат (Портер):
ЭЗ-ийн амжилттай хөгжил гэдэг нь үе шаттайгаар байнга шинэчлэгдэх үйл явц

1. Хүчин зүйлд тулгуурласан үе шат

Өрсөлдөөний давуу тал нь зөвхөн хөдөлмөр, байгалийн нөөцийн хишиг дээр суурилдаг. Харьцангуй бага цалин хөлсийг дэмждэг.

2. Хөрөнгө оруулалтад суурилсан үе шат

ЭЗ үйлдвэрлэл, аутсорсинг үйлчилгээний экспортод төвлөрдөг. Цалин өндөр боловч санхүүгийн хямрал, гадаад зах зээл, салбарын онцлог зэрэг эрэлтийн шоконд өртөмтгий байдаг.

3. Инновацид суурилсан үе шат

Хамгийн дэвшилтэт аргыг ашиглан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэх нь өрсөлдөөний давуу тал болдог. ААН-үүд нь дэлхийн хэмжээний стратегиудтай өрсөлдөж, дэвшилтэт ур чадвар, шинэ технологи, чадавхид хүчтэй хөрөнгө оруулдаг.

- Үйлдвэрлэл, худалдааны бодлого
 - Засгийн газрын зохих үүрэг бол катализатор, соригч байх.
 - Өрсөлдөөнийг зохицуулахаас зайлсхийх.
 - Төрийн монополийг хадгалах, тухайн салбарт орж ирэхийг хянах, үнэ тогтоох зэрэг бодлогоор өрсөлдөөнийг зохицуулах нь хоёр хүчтэй үр дагавартай: Компаниуд зохицуулагчидтай харьцах, өөрт байгаа зүйлээ хамгаалахад анхаарлаа хандуулснаар өрсөлдөөн, инновацийг боомилдог; Мөн тухайн салбарыг эрч хүчгүй, идэвхгүй болгодог.
 - Худалдааг удирдан зохицуулахаас татгалзах.
 - Захиалгат маркетинг, хязгаарлалт эсвэл тоон зорилт тодорхойлсон арга хэмжээ нь зах зээлийг хувааж үр ашиггүй, аюултай болгодог бөгөөд ихэвчлэн хэрэглэгчдэд асар их зардал нэмэгдэж очдог. Түүнчлэн зохицуулалттай худалдаа нь үр ашиг муутай компаниудыг дэмжиж, тэдэнд зах зээл бий болгож байдаг. Худалдааны бодлогын үүрэг бол зөвхөн хүндрэлтэй салбарт туслах биш, харин тухайн улсын өрсөлдөх давуу талтай салбаруудад нээлттэй зах зээлийг бий болгох тухай юм.
- Бүтээгдэхүүний, аюулгүй байдлын, байгаль орчны стандартыг чанд мөрдүүлэх. (Портер, 1990)




БНХАУ-ын гадаад худалдааны өнөөгийн байдал

- БНХАУ зах зээлийн эдийн засагт шилжсэнээр, ДНБ нь 30 гаруй жилийн турш хоёр оронтой тоогоор өсч, 2009 онд дэлхийн хоёр дахь том эдийн засаг, 2010 онд дэлхийн хамгийн том экспортлогч болжээ. 2021 онд тус улсын ДНБ 16.8 их наяд ам.долларт хүрч, дэлхийн нийт ДНБ-ний 17.8 хувийг бүрдүүлж байна.
- Олон улсын худалдаа, эдийн засгийн харилцаанд Хятад улсын эзлэх байр суурь эрс өссөн нь нэг талаас нөөц баялгийн хишиг, даяаршлын үр нөлөөг хүртсэнийх бол, нөгөө талаас тус улсын засгийн газраас явуулсан тогтолцооны шинэтгэлийн үр дүн юм.
- Тус улсын ДНБ-ний 35 орчим хувийг гадаад худалдаанаас бүрдүүлж буй (2020) бөгөөд тус салбарыг эдийн засгийг шинэчлэх чухал хэрэгсэл хэмээн үзэж, улам бүр нээлттэй болгохыг зорьж буй.
- Нийт экспорт, импортод үйлчилгээний худалдаа харьцангуй бага буюу 10 орчим хувийг эзэлж байна.

БНХАУ-ын гадаад худалдааны өнөөгийн байдал

БНХАУ-ын худалдааны голлох түнш улсууд



БНХАУ-ын гадаад худалдааны зарим үзүүлэлт (ДНБ-д эзлэх хувиар)

Гадаад худалдааны үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	2021
Экспорт	17.7	18.1	17.5	16.6	16.8	18.3
Импорт	13.4	14.2	14.7	13.9	13.3	15.3
Худалдааны тэнцэл	4.4	3.9	2.7	2.7	3.5	3.0
Үйлчилгээний тэнцэл	-2.1	-2.1	-2.1	-1.8	-1.0	-0.7

БНХАУ-ын экспортын голлох бүтээгдэхүүн	БНХАУ-ын импортын голлох бүтээгдэхүүн
Цахилгаан, электрон тоног төхөөрөмж (27 хувь)	Цахилгаан ба электрон тоног төхөөрөмж (27 хувь)
Машин механизм, цөмийн реактор, бойлер (17 хувь)	Түлш, тос, нэрмэл бүтээгдэхүүн (13 хувь)
Тавилга, гэрэлтүүлгийн тэмдэг, угсардаг барилга (4,2 хувь)	Машин механизм, цөмийн реактор, бойлер (9,3 хувь)
Хуванцар (3,7 хувь)	Төмрийн хүдэр (8,8 хувь)
Нэхмэл эдлэл, хувцас (2.9 хувь)	Төмөр зам, трамвайнаас бусад тээврийн хэрэгсэл (3,6 хувь)

БНХАУ-ын гадаад худалдааны хөгжлийн бодлогын хувьсал, өөрчлөлт

Худалдааг чөлөөлөх бодлогын үе (1979-1987 он)

- ❑ Эрх мэдлийг шилжүүлэх, төвлөрлийг сааруулах
- Экспортын татварын хөнгөлөлт
- Гадаад валютын чөлөөтэй хөрвөх тогтолцоо
- Хөдөлмөр их шаарддаг бүтээгдэхүүний экспортыг өргөжүүлэх

Олон улсын интеграцид нэгдэх бодлогын үе (1988-1993 он)

- ❑ Олон улсын худалдаа, эдийн засгийн мөчлөгт аль болох оролцох, “ихээр оруулах, ихээр гаргах” бодлого
- Худалдааны хэмжээг өсгөх зорилгоор гадаад худалдааны ААН-үүдийн үйл ажиллагааны эрх чөлөөг аажмаар нэмэгдүүлсэн
- 1991 оноос экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн татаасыг цуцалснаас гадна гадаад худалдааны ААН-үүдийг заавал биелүүлэх төлөвлөгөөнөөс чиглүүлэх шинжтэй төлөвлөгөөнд шилжүүлж, ерөнхийд нь хянах
- Импортын барааны татварыг бууруулах зэргээр “Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр” (ГАТТ)-т нэгдэх бэлтгэл ажил хийж эхэлсэн

Цогц шинэтгэлийн үе (1994-2001 он)

- ❑ Нээлттэй үйл ажиллагаа, эрх тэгш өрсөлдөөн, өөрийгөө санхүүжүүлэх, аж үйлдвэр-худалдааны интеграцчилал, агентийн тогтолцоо
- ❑ “Гадаад худалдааны хууль”-ийг баталж хэрэгжүүлсэн бөгөөд үргэлжлүүлэн “Импорт, экспортын зохицуулалтын журам”, “Экспортын барааны зохицуулалтын журам”, “Демпингийн ба нөхөн төлбөрийн эсрэг журам” зэрэг гадаад худалдааны эрх зүйн үндсэн тогтолцоог бий болгосон

БНХАУ-ын гадаад худалдааны хөгжлийн бодлогын хувьсал, өөрчлөлт

Эдийн засгийн даяаршлын үе (2002-2008 он)

- ❑ 2001 оны 12 дугаар сард Дэлхийн худалдааны байгууллагад элссэн
- ДХБ-ын дүрэм журам болон өгсөн амлалтаа биелүүлэхийн тулд аж үйлдвэр, ХАА, үйлчилгээний салбарын гадаад ертөнцөд нээлттэй байдлыг өргөжүүлэхийн зэрэгцээ худалдаа, үйлчилгээ, оюуны өмчийн эрхтэй холбоотой хууль тогтоомжид өргөн хүрээний нэмэлт, өөрчлөлт хийжээ.

Тооноос чанарт шилжих бодлогын үе (2008 оноос)

- ❑ 2008 оны дэлхийн санхүүгийн хямрал, загварын сорилт
- XI ТЖТ (2008-2012 он)-ний үеэс гадаад худалдааг тоо хэмжээний өсөлтөөс чанартай хөгжилд шилжүүлэх бодлого
- XII ТЖТ (2012-2016 он)-ний үеэс “худалдаа, эдийн засгийн хөгжлийн хэлбэр”-ийн өөрчлөлтөд тууштай анхаарсан
- 1-рт, нийт эрэлтийн бүтцийг өөрчлөх, үүнд экспорт, ХО-аар эдийн засгийн өсөлтийг хангахаас хэрэглээ, экспорт, ХО-аар тохируулсан өсөлтөд шилжих;
- 2-рт, нийлүүлэлтийн бүтцийг өөрчлөх, үүнд аж үйлдвэрт түшиглэсэн бүтцээс ХАА, аж үйлдвэр, үйлчилгээний салбарт адил түшиглэх;
- 3-рт, хүчин зүйлсийн оролтын өөрчлөлт, тоо хэмжээний өсөлтөөс мэдлэг, технологи, менежментийн цогц сайжруулалт хийх.

Худалдааны хүчирхэг улс болох, манлайлал үзүүлэх стратеги (2021 оноос)

- ❑ Худалдааны тэнцэл болон аж үйлдвэрийн хөгжлийг зохицуулж, худалдааны хүчирхэг улс болох
- 1-рт, технологийн болон институцын инновац
- 2-рт, анхан шатны үйлдвэрлэлийн гарцыг нэмэгдүүлэх, уламжлалт үйлдвэрлэлийн салбарыг цахимжуулах замаар “хил дамнасан цахим худалдаа + шинэ үйлдвэрлэл” формат
- 3-рт, үйлчилгээний худалдааг өндөр түвшинд нээж эдийн засгийн хөгжлийн “шинэ хөдөлгүүр” болгох.

БНХАУ-ын гадаад худалдааны хөгжлийн бодлогын хувьсал, өөрчлөлт

- Дээрх бодлогуудын үр дүнд Хятадын ГХ-ны цар хүрээ өргөжин тэлж, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний экспортод эзлэх хувь тасралтгүй өсч, хөдөлмөр, нөөц шаардсан бүтээгдэхүүнийг аажмаар хөрөнгө, технологи шаардсан бүтээгдэхүүн орлох болсон.
- Тус улсын ГХ-г хөгжүүлэх стратеги амжилттай хэрэгжсэн боловч урт хугацааны экспортыг дэмжих чиг баримжаа нь зарим тэнцвэргүй байдал, тухайлбал, дундаж болон хямд үнэтэй бүтээгдэхүүний илүүдэл, өндөр зэрэглэлийн бүтээгдэхүүний дутагдалтай байдлыг үүсгэсэн байдаг.


Он	Анхан шатны бүтээгдэхүүн		Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн					
			Нийт		Машин механизм, цахилгаан бүтээгдэхүүн		Өндөр, шинэ технологийн бүтээгдэхүүн	
	Экспорт	Импорт	Экспорт	Импорт	Экспорт	Импорт	Экспорт	Импорт
1985	50.5	12.4	49.5	87.6	6.1	43.6		
1990	25.6	18.5	74.4	81.5	17.9	40.2		
1995	14.4	18.5	85.6	81.5	29.5	44.8	6.8	16.5
1998	11.2	16.4	88.8	83.6	36.2	45.6	11	20.8
1999	10.2	16.2	89.8	83.8	39.5	46.8	12.7	22.7
2000	10.2	20.8	89.8	79.2	42.3	45.7	14.9	23.3
2001	9.9	18.8	90.1	81.2	44.6	49.5	17.5	26.3
2002	8.7	16.7	91.3	83.3	48.2	52.7	20.8	28.1
2003	7.9	17.6	92.1	82.4	51.9	54.5	25.2	28.9
2004	6.8	20.9	93.2	79.1	54.5	53.8	27.9	28.8
2005	6.4	22.4	93.6	77.6	56	53.1	28.6	30.0
2006	5.5	23.6	94.5	76.4	56.7	54	29.1	31.2
2007	5.1	25.4	94.9	74.6	57.6	52.2	28.6	30
2008	5.4	32.0	94.6	68.0	57.6	47.5	29.1	30.2
2009	5.3	28.8	94.7	71.2	59.3	48.9	31.4	30.8

БНХАУ-ын гадаад худалдааны хөгжлийн бодлогын хувьсал, өөрчлөлт


БНХАУ-ын гадаад худалдааны хөгжлөөс харахад, ерөнхийдөө гурван голлох бодлогын хувьсал явагдаж байна:

- 1-рт, экспортын баримжаатай стратегиас импорт, экспортод адил ач холбогдол өгөх, үйлдвэрлэлийн салбарын нээлттэй байдлаас үйлчилгээний салбарын нээлттэй байдалд хүрэх, зарим үйлдвэрлэлийг хамгаалах бодлогоос аажмаар бүх үйлдвэрлэлийг нээлттэй болгох;
- 2-рт, зүүн бүсээ эхэлж хөгжүүлэх бодлогоос бүс нутгийн зохицуулалттай хөгжилд, далайн эргийн бүсүүдийн нээлттэй байдлаас төвийн бүсийн өсөлтөд, цаашлаад “Бүс ба зам”-ын хамтын бүтээн байгуулалт, бүс нутгийн нээлттэй хэлбэрт шилжих;
- 3-рт, олон улсын эдийн засаг, худалдааны дүрэм журмыг хангах бодлогоос манлайлал үзүүлэх, хамгийн өндөр стандартуудыг хангах (Хятад стандарт 2035).

БНХАУ-ын гадаад худалдааны хөгжлийн голлох сорилт ба боломж



Source: The Economist Intelligence Unit.



- Тус улсын АНУ-тай хийж буй стратегийн өрсөлдөөний улмаас хөгжингүй орнууд, ялангуяа АНУ эдийн засгийн “тусгаарлах” бодлого явуулж, тус улсын эсрэг нэгдэх, зах зээлээ хамгаалах, боловсруулах аж үйлдвэрүүдээ буцаан татах зэрэг бодлого барих нь гадаадын капиталыг ашиглах боломжийг бууруулж, тус улс руу чиглэх дунд, өндөр зэрэглэлийн үйлдвэрлэлийн шилжилтийг удаашруулж, боловсруулах үйлдвэрлэлийн шинэчлэлийг хязгаарлах магадлал өндөр.
- Гэхдээ тус улс дэлхийн бусад зах зээлд нөлөөгөө тэлсээр байна. Тухайлбал, 2020 оны 11 дүгээр сард Бүс нутгийн эдийн засгийн цогц түншлэл (RCEP)-д 14 улстай гарын үсэг зурж, Ази, Номхон далайн бүс нутаг дахь харилцаа холбоогоо бэхжүүлсэн байна.
- Цаашид БНХАУ, Европын холбооны хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурах, БНХАУ, Япон, БНСУ-ын чөлөөт худалдааны хэлэлцээрийн явцыг түргэтгэх, Номхон далайг дамнасан иж бүрэн, дэвшилтэт түншлэлийн хэлэлцээр (СРТРРА)-т нэгдэх талаар нухацтай авч үзэх ажээ.
- Түүнчлэн “Бүс ба зам” санаачилгыг дэмжигч улс орнуудтай стратеги, төлөвлөгөө, механизм, дүрэм, стандартаа уялдуулах замаар худалдаа, эдийн засгийн харилцааг гүнзгийрүүлэх, ногоон, агаарын, мөсөн, дижитал, инновацын торгоны зам, орон зайн мэдээллийн коридор зэргийг байгуулахыг зорьж байна.

- Гадаад орчны сорилтоос илүү “дотоод асуудал”-ын шийдэл тулгамдаж байна. (Төрийн институцуудын чадавх, авилга, логистик, стандарт ...)
- Экспортыг дэмжих, эдийн засгийг төрөлжүүлэх олон бодлого, хөтөлбөр баталсан хэдий ч үр дүнтэй, биелэлт сайтай бодлого, хөтөлбөр ховор байна.
- Худалдааны харилцааг олон салбарын хуулиар хэсэгчлэн зохицуулдаг, бодлого боловсруулалт, хэрэгжилтийг хариуцсан газар байхгүй, худалдааны чиг үүрэг хариуцсан бүтцэд олон удаагийн өөрчлөлт орж байсан нь бодлогын залгамж чанар, уялдаа холбоо, хүний нөөцийн мэргэшсэн байдалд сөрөг нөлөө үзүүлжээ.
- Зах зээлийн эдийн засгийн дүрмээр тоглох, тухайлбал, өрсөлдөх давуу талтай салбарууддаа чөлөөт өрсөлдөөн бий болгох, төрийн оролцоог эрс багасгах.

- БНХАУ өндөр хөгжсөн улсуудын эдийн засгийн хөгжлийн түүх, онол, сургаалиас суралцаж, үндсэндээ адил арга замаар эдийн засгаа хөгжүүлж байна.
- Гадаад худалдааны хөгжлийг шат дараатай, прагматик, тогтвортой бодлогоор хангаж, тухайн бодлогын үр ашигтай байдал буурах үед өөрчлөлт, шинэчлэлийг цаг алдалгүй хийсээр байна.
- Сүүлийн үеийн стратеги нь сул талаа нөхөх, давуу талаа бэхжүүлэхэд анхаарч, экспортоос гадна чанартай импортыг тэлж аж үйлдвэрийн шинэчлэлийг тэтгэх, үйлчилгээний худалдааг хөгжүүлэх, инновацаар технологийн болон институцын чадавхаа сайжруулах, улмаар олон улсын худалдаа, эдийн засгийн харилцаанд “дүрэм дагагч бус, дүрэм тогтоогч” болох амбицтай байна.
- Цаашид манай улсын аж үйлдвэр, худалдааны хөгжилд Хятад төвтэй нэмүү өртгийн сүлжээ томоохон нөлөө үзүүлнэ.



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН

Анхаарал хандуулсанд баярлалаа.